

2021 он 04 сар 30 өдөр

Дугаар 21/01

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 сарын 30-ны өдөр live.ard.mn цахим хуудсаар дамжуулан 14:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, хурлын дэг болон хуралд урилгаар оролцож буй ТУЗ-ийн гишүүд, Удирдлагын алба, Грант Торнтон аудитын төлөөлөл, Тооллогын комиссын гишүүн төлөөллийг тус тус танилцуулан Тооллогын комиссын даргыг хурлын ирцийг танилцуулахаар урив.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх танилцуулснаар: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нийт гаргасан хувьцааны 28,614,263 ширхэг хувьцаанаас саналын эрхгүй охин болон хараат компанийн эзэмшиж буй 9,119,529 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс саналын эрхтэй 19,494,734 ширхэг энгийн хувьцаанаас саналын эрхтэй 12,729,301 ширхэг буюу 65.3 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцож байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээллэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.13-ыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хурлын даргад мэдэгдэж, хурлыг нээв.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр хурлын дэгийг танилцуулан 2020 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж эхлэв.

Хурлын дэг:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.

Хэлэлцсэн нь №1: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг:

2020 оны онцлох үйл явдлуудын хувьд Монголын Хөрөнгийн Бирж бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд болох Ард Даатгал ХК, Ард Кредит ББСБ ХК нь 2020 оны ТОП 20 инлексийн жагсаалтанд орсон. Мөн 2 сард компаний тухай хуулийн дагуу Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 2019 оны нийт ашгийн

12.65 хувь болох 1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 34.95 төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэж 2020 оны 6 сарын 30-ны өдөр “ҮЦГХТ” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан. Үүнээс гадна бид Монгол ТВ-тэй хамтран Аппрентис Монголиа шоу амжилттай зохион байгуулан шигшигдэж үлдсэн чадварлаг залуу Ц.Бархасыг багтаа нэгтгэн авсан. Ирээдүйн эзэд болох “Хувьцаатай хүүхэд” аянг эхлүүлж одоогоор нэг мянга орчим хүүхдүүд хувьцаатай болсон байна. 2020 оны 9 сарын ТУЗ-ийн хурлаар 2020 оны хараат бус аудитын компаниар олон улсын Грант Торнтон аудит ХХК-г томилсон. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт байдлаар явуулж нэмэлт өөрчлөлтийг баталсан. Мөн олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болох EuroGiro-г Монгол Шуудан ХК-тай хамтран Монголд анх удаа нэвтрүүлсэн. Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний “Автомат клиринг хаус” системд Ард Кредит ББСБ ХК 2020 оны 12 сард амжилттай холбогдож чадсан. Ард Кредит ББСБ ХК нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу цахим мөнгө, төлбөрийн карт хүлээн авах үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд тус системд холбогдсоноор төлбөр тооцоо нь бодит цагийн горимоор хийгдэх боломжтой болсон. Үүнээс гадна Ард Кредит ББСБ ХК нь Монголбанкнаас цахим мөнгөний тусгай зөвшөөрлөө аван АрдКэш нэртэй шинэ цахим мөнгийг бий болгосон. АрдКэш нь Ард Санхүүгийн Нэгдлийн зах зээл дээр нэвтрүүлсэн Ард Аппаар төлбөр тооцоо хийхэд ашиглагдах бөгөөд цахим хэлбэрээр хадгалагдаж, цаанаа мөнгөн хөрөнгөөр баталгаажсан цахим мөнгө юм. АрдКэш нь төгрөгт, төгрөг нь АрдКэшд чөлөөтэй хөрвөх боломжтой. Ийнхүү Ард Аппын хэрэглэгчдэд зээл авах, үнэт цаасны арилжаанд оролцох, онлайн худалдаа хийх, мөнгө гуйвуулах, төлбөр тооцоо хийх зэрэг АрдАпп дээр санал болгож буй бүх үйлчилгээнд нэг дороос хамрагдах боломжийг олгож байгаа юм. АрдШопын Гүйцэтгэх захирлаар Б.Ариунааг томилж, компаний төлөвлөгөө болон зорилгыг шинэчилсэн. Ард Секюритиз ҮЦК нь Монголын хамгийн том брокеруудын нэг болсон бөгөөд гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан. Монголын хамгийн анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний Хувьчлалын Сан”-ийн үйл ажиллагааг эхлүүлж 5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

2021 оны онцлох үйл явдлуудын хувьд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн зах зээлийн үнэлгээ 100 сая доллар буюу 300 тэрбум төгрөгийн босгыг давсан. 2021 он гарсаар 88 ажлын байрыг шинээр бий болгож, ажлын байраа өргөжүүлсэн. Богд Банк нийт хөрөнгийнхөө 20 хувийг олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани болох шийдвэр гаргасан бөгөөд үндсэн андеррайтераар Ард Секюритиз ҮЦК хамтран ажиллахаар болсон. Мөн Ард Холдингс Интернэшнл ХХК Богд Банктай Стратегийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, 11.7 хувийг эзэмших болсон. Богд Банк нь шинээр хувьцаа нэмж гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргаж, хувьцаагаа нийтэд санал болгохын өмнөх шат буюу Pre-IPO болох стратегийн хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг Монголбанкнаас авч ажиллахаар төлөвлөж байна. Үүнээс гадна Ард Секюритиз ҮЦК Гацуурт компанийн 40 тэрбум төгрөгийн хаалттай бондыг гаргаж, хөрөнгөө амжилттай татан төвлөрүүлэв.

Танилцуулсан нь: Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нийт үнэлгээ 2020 оны эцсийн байдлаар 59 тэрбум төгрөг байсан нь 2021 оны 1-р улиралд 408 тэрбум төгрөг болж өссөн бөгөөд нийт хөрөнгө нь 2020 оны эцсээр 80 тэрбум төгрөг байсан нь 2021 оны 1-р улиралд 437 тэрбум төгрөг болж тус тус өссөн байна. Цэвэр ашгийн хувьд 2020 онд бид 4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2021 оны 1-р улирлын байдлаар 14.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Дэлгэрэнгүй ашгийн хувьд 2019 онд 5.4 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 200 сая төгрөг болж буурсан байна. Энэ нь хөрөнгийн зах зээлийн уналт болон дэлхий даяарх цар тахалтай холбоотой эдийн засгийн нөлөөтэй уналт байсан юм. Гэсэн хэдий ч бид 2021 оны 1-р улиралд энэхүү ашгаа нөхөж, 304 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашигтай ажилласан байна. Энэхүү дэлгэрэнгүй ашгийг бүрдүүлэх гол хүчин зүйлсийн нэг бол хөрөнгө оруулалтын багц бөгөөд 2020 оны эцсийн байдлаар Ард Санхүүгийн Нэгдлийн стратегийн багц 67 тэрбум төгрөг, тактикийн багц 50 сая төгрөг байсан бол 2021 оны 1-р улирлын эцсийн байдлаар стратегийн багц 245 тэрбум, тактикийн багц 23 тэрбум болж өссөн байна. Ингэснээр нийт хөрөнгө оруулалт 268 тэрбум төгрөг болсон бөгөөд эздийн өмч 2020 оны эцэст 55.8 тэрбум төгрөг байсан нь 2021 оны 1-р улиралд 377 тэрбум төгрөг болж өссөн байна.

Танилцуулсан нь: Грант Торнтон аудит ХХК-ийн Партнер Н.Эрдэнэцогт:

Грант Торнтон аудит компанийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр илэрхийлэгдсэн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Компаний удирдлага санхүүгийн тайлангаа үнэн зөв илэрхийлэх үүрэгтэй байдаг бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй байдаг. Аудиторын хувьд санхүүгийн тайлан үнэн зөв зөрчилгүй илэрхийлэгдсэн байгаа эсэх дээр ул үндэслэлтэй нотолгоо олж дүгнэх үүрэгтэй байдаг. 2020 оны хувьд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн санхүүгийн тайлан зөрчилгүй гэсэн санал дүгнэлтийг Грант Торнтон аудит ХХК-аас өгсөн байна. Нийт хөрөнгө 80.4 тэрбум төгрөг, нийт хөрөнгө оруулалтын орлого 2.3 тэрбум төгрөг, нийт алдагдал 4 тэрбум төгрөг, нийт дэлгэрэнгүй орлого 200 сая төгрөгөөр тус тус баталгаажсан. Ард Санхүүгийн Нэгдлийн 2020 оны санхүүгийн тайлан СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлтийг бид өгсөн.

Хэлэлцсэн нь №2: Компаний 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дарга П.Батбаяр:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ нь тайлант онд компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн шийдвэр, зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

2019 оны 12 сарын 12-ны ТУЗ-ийн ээлжит хурлаар компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. ТУЗ-ийн баталсан 2020 оны Бизнес төлөвлөгөөний гол зорилгоо биелүүлэн Монголын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан IPO-оо амжилттайгаар хийж, үйл ажиллагааг эхлүүлэв, Ард Апп-ын 4 дэхь хувилбарыг боловсруулан Digital Assets Exchange буюу Виртуал Хөрөнгийн Бирж (DAX.mn) болох блокчэйн технологид суурилсан крипто, секюрити токен арилжаалах платформоо олон нийтэд танилцуулсан. Монгол Шуудантай хамтран EugoGiro олон улсын мөнгөн гуйвуулгын сүлжээний үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Мөн 2020 онд дэлхий даяар корона вирусын цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа тасалдах эрсдэлтэй энэ үед Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хөрөнгө оруулалттай компаниуд ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан нь бизнесийн өвөрмөц шийдэл байсан бөгөөд Ард Кредит 1.1 тэрбум, Ард Даатгал 850 сая, Ард Санхүүгийн Нэгдэл 1 тэрбум төгрөгийг тус бүр хувьцаа эзэмшигчиддээ хуваарилсан юм.

Хөндлөнгийн аудитын дүгнэлт хийлгүүлэхээр Грант Торнтон олон улсын аудитын компанийг сонгон ажиллуулсан бөгөөд энэхүү 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2021 оны 4 сарын ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан.

Иймд 2020 он Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьд асар том амжилт, өгөөжтэй жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дайчлан ашиглан төлөвлөсөн зорилтоо биелүүлэн ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

Хэлэлцсэн нь №3: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дарга П.Батбаяр:

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн сонголтоор хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлж дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл компанийг удирдан чиглүүлж гүйцэтгэх удирдлагуудтай хамтран ажилладаг. Компаний дүрмээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг 2 жил тутам сонгоно гэсэн заалттай байдаг бөгөөд үүний дагуу бид энэ хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлөө сонгох шаардлагатай байгаа юм.

ТУЗ-ийн дарга П.Батбаяр ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй хүмүүсийг танилцуулав.

Ердийн гишүүнд: Чулуун овогтой Ганхуяг, Одончимэд овогтой Одбаяр, Авир овогтой Сүхдорж, Бруно Рашле нарыг тус тус нэр дэвшүүлэв.

Хараат бус гишүүнд: Пүрэвжаргал овогтой Батбаяр, Чулуун овогтой Мөнхбат, Мөнх-Очир овогтой Сүхдорж, Михаил Зелдович, Арно Вентура нарыг тус тус нэр дэвшүүлэв.

Асуулт, хариулт

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Цог Билгүүн, Намжил Мөнх-Очир, Болортулга Намуунаа.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК хэзээ олон улсын хөрөнгийн бирж дээр гарах вэ?

Хариулт. Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг:

Бид олон улсын бирж дээр гарах ажлаа эхэлсэн. Энэ дээр маш олон цогц ажлууд авагдах болно. Бид оюуны хөдөлмөр дээр тулгуурласан, хамтын хүчээр бий болгосон компанийг олон улсад хувьцааг нь гаргаж борлуулах ажлыг явуулж байгаа.

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Батсайхан Золжаргал, Энхтуяа Батням, Энхсүх Алтансүх.

Компаний нийгмийн хариуцлагын хүрээнд ямар үйл ажиллагаа хийж байгаа вэ?

Хариулт. Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг:

Нийгмийн хариуцлагын хүрээний хувьд бид ТУЗ-тэй зөвлөлдөн Хөрөнгө оруулалтын буяны сан байгуулах ажлыг эхлүүлэх болно.

Асуулт, хариулт дуусав.

Санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /19,494,734 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,729,301 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /19,494,734 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,729,301 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /19,494,734 ширхэг/		Хуралд оролсон нийт саналын эрхтэй хувьцаа /12,729,301 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
19,494,734	100%	12,392,732	97.36%	19,494,734	100%	4,366	0.03%	19,494,734	100%	1,355	0.01%

2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох асуудлаар:

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

Чулууны Ганхуяг 15,117,752 ширхэг санал;

Авирдоржийн Сүхдорж 11,560,490 ширхэг санал;

Бруно Е. Рашле 11,569,869 ширхэг санал;

Одончимэдийн Одбаяр 11,472,868 ширхэг санал;

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

Пүрэвжаргалын Батбаяр 11,464,125 ширхэг санал;

Мөнх-Очирийн Сэргэлэн 11,387,764 ширхэг санал;

Чулууны Мөнхбат 11,156,893 ширхэг санал;

Михаил Зелдович 11,082,728 ширхэг санал;

Арно Вентура 11,588,966 ширхэг санал тус тус авсан байна.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
2. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ч.Ганхуяг, А.Сүхдорж, Бруно Рашле, О.Одбаяр нар сонгогдов. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр П.Батбаяр, М.Сэргэлэн, Ч.Мөнхбат, Михаил Зелдович, Арно Вентура нар сонгогдов.

Хурал 16 цаг 40 минутанд дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга



Ч.Ганхуяг

Х.Хулан